

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловруулж, батлан хэрэгжүүлж байна.

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**



АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	<i>Товчилсон үгийн тайлбар</i> 3
Төв аймаг дахь Төрийн Аудитын газар	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт</i> 4
Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал	<i>Ерөнхий мэдээлэл</i> Бүлэг 1 <i>Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө гаргаагүй байна.</i>
Аудитын менежер О.Амаржаргал	Бүлэг 2 <i>Аймаг, орон нутагт хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах хугацаа болоогүй байна.</i>
Ахлах аудитор Л.Жаргалсайхан Аудитор Ч.Загдсүрэн	Бүлэг 3 <i>Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байна</i>
2017 оны 12 дугаар сарын 20 <i>Уг тайланг</i> www.audit.mn сайтаас үзнэ үү	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын 2-р байр	

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ шинжилгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ.

Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулсан эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөгдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний харьяа хэлтэс, байгууллага, Засаг даргын тамгын газрыг хамрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдаж улмаар УИХ-ын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлагдсан. Эдгээрт нийцүүлэн Төв аймгийн ИТХурлын 2016 оны 10-р сарын 14-ны өдрийн II хуралдааны 01 тоот тогтоолоор “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн III Хуралдааны 01 тоот тогтоолоор “Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, 2017 оны 2-р сарын 20-ны өдрийн IV хуралдааны 02 тоот тогтоолоор “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилт тус тус батлагдсан.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт 2017-2020, 2020-2024 гэсэн хоёр үе шаттай хэрэгжихээр батлагдаж энэхүү баримт бичгийн зорилго, зорилттой аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн үндсэн чиглэлийг нийцүүлэн боловсруулан баталж, хэрэгжүүлж байна.

Сумдын хувьд аймаг хөгжүүлэх хэтийн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтын

хүрээнд тухайн сумын онцлогыг тусган сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлээ боловсруулан баталж, хэрэгжүүлж байна.

Эрсдлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “дунд” гэж үнэлсэн.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглана.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төсвийн тухай хууль,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль,
- Засгийн газрын тухай хууль,
- Хууль тогтоомжийн тухай хууль,
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль,
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”,
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”,
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө,
- Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх “Үндэсний хөтөлбөр”-ийн жагсаалт,
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нар хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2017 оны 10 дугаар сарын 9-нд эхэлж, 12 дугаар сарын 20-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлээ.

Ерөнхий мэдээлэл

Төв аймгийн хувьд 2008 онд “Аймгийн хөгжлийн хөтөлбөр 2008-2023”, “Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр 2007-2016” зэрэг урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийг Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ирсэн.

Аймгийн дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг ХБТТХууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх шаардлага тулгарсан.

2016 оны 6 дугаар сард болсон орон нутгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн үр дүнд байгуулагдсан ИТХурал, шинээр томилогдсон Засаг дарга аймаг хөгжүүлэх хэтийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн ИТХурлын 2016 оны 10-р сарын 14-ны өдрийн II хуралдааны 01 тоот тогтоолоор “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн III Хуралдааны 01 тоот тогтоолоор “Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, 2017 оны 2-р сарын 20-ны өдрийн IV хуралдааны 02 тоот тогтоолоор “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилт тус батлагдсан.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт буюу “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” баримт бичиг нь эдийн засаг, нийгэм, байгаль орчины тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн засаглал гэсэн 4 бүлгийн хүрээнд 22 зорилго, 103 зорилттойгоор боловсруулагдаж батлагдсан. Энэхүү баримт бичигт алсын харааг “Нийт өрхийн дийлэнхийг дундаж ба дунджаас дээш амьдралтай болгоход чиглэнэ”, эрхэм зорилгоо “хүнээ эрхэмлэн дээдэлсэн, байгаль орчинд ээлтэй, зах зээлд өрсөлдөх чадвартай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, тогтвортой өсөлттэй, өөрийгөө тэтгэх, оновчтой бүтэц бүхий эдийн засагтай аймаг болоход оршино” гэж тодорхойлжээ.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого, дэд бүтэц, төв суурингийн хөгжлийг хангах бодлого, байгаль орчин ногоон хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн бодлого, нутгийн удирлага, хууль хяналтын салбар гэсэн зургаан үндсэн үзүүлэлтээр 112 зорилт, 377 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлагдсан. Мөн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 27 дэд хөтөлбөр баталж хэрэгжүүлэхээр жагсаалт батлагдсан. Эдгээрээс одоогийн байдлаар 18 дэд хөтөлбөр аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн болон аймгийн Засаг даргын шийдвэрээр батлагдаад байна. /Хавсралт 1-д харуулав/

Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зургаан үндсэн үзүүлэлтээр 140 зорилт, 498 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлагдсан.

Сумдын хувьд Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл гэсэн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтод нийцүүлэн тухайн сумын хөгжлийн онцлогыг тусган сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулан батлуулж хэрэгжүүлж байна. /Хавсралт 2-д харуулав/

Аудитаар аймаг, орон нутагт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд хамрагдах аймаг хөгжүүлэх хэтийн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл гэсэн бодлогын баримт бичгүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх асуудлыг авч үзлээ.

Нийцлийн аудитын зорилт нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоо бүрдсэн эсэхэд чиглэгдсэн бөгөөд аймаг орон нутгийн хувьд аймаг хөгжүүлэх хэтийн зорилтод тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд аймаг сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сум хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулагдан батлагдаж, хэрэгжиж байгаа тул аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх явцыг хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлж буй байдлыг түлхүү авч үзэж тайланд тусгалаа.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулсан эсэх

Бүлэг 1

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө гаргаагүй байна.

А.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, төлөвлөгөө боловсруулан ажилласан уу?

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг журмын 17-д заасны дагуу төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 8 дугаар сарын 12-ны А/475 тоот захирамжаар “Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл 2017-2024”, “Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл боловсруулах нэгдсэн ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан, аймгийн ЗДТГазрын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтэн, ИТХ-ын тэргүүлэгч, нарийн бичгийн дарга, мэргэжилтэн, харьяа агентлаг төсвийн байгууллагуудын дарга нийт 31 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын гуравдугаар бүлгийн 17-д “журмын 12, 13-т заасан ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна”, 18-д “Төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгана: 18.1-д нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх; 18.2-т нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох; 18.3-д хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах; 18.4-т бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх; 18.5-д хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах; 18.6-д хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах” гэж заасан.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан нэгдсэн ажлын хэсэг дээр дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө гарган баталж ажиллаагүй байна.

Мөн журмын 19-р зүйлд “Ажлын хэсэг төсөл, бодлогын хувилбаруудын төслийг эцэслэн боловсруулж, холбогдох хавсралтын хамт захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх” гэж заасан.

Энэ заалтын дагуу ажлын хэсэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хувилбаруудыг эцэслэн боловсруулж, журмын 18.1-18.6-д заасан ажиллааг хийн

хавсралт маягтуудаар гарган аймгийн ЗДТГазарт хүлээлгэн өгөхөөр заасан боловч хавсралт маягтуудыг гаргаагүй, хүлээлгэн өгөөгүй байна.

A.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн, шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулсан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн, шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг хангасан байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн, шинжилгээг өмнө нь хэрэгжиж ирсэн баримт бичгүүдийн хэрэгжилт, статистикийн байгууллагын албан ёсны мэдээлэл, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт зэрэгт тулгуурлан 2016 оны хүрсэн түвшинг тодорхойлсоны үндсэн дээр хийжээ. Төв аймгийн хөгжлийн өнөөгийн байдал, орчны шинжилгээг 2008-2016 оны эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, байгаль орчин, нийгэм, хүн ам, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг статистик тоон үзүүлэлт, тэдгээрийн өсөлт бууралтыг улс, бүс нутгийн дундажтай харьцуулан, санхүүгийн эх үүсвэр, бүс нутгийн нөөц боломжийг тодорхойлон SWOT шинжилгээний аргаар хийж зорилго зорилтуудаа тодорхойлсон байна.

“ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ-2024” АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ

Үзүүлэлт	Зорилгын тоо	Зорилтын тоо
Эдийн засгийн тогтвортой хөгжил	11	58
Нийгмийн тогтвортой хөгжил	7	14
Байгаль орчны тогтвортой хөгжил	1	7
Тогтвортой хөгжлийн засаглал	3	24
НИЙТ	22	103

Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт нь 4 үндсэн үзүүлэлтээр 22 зорилго, 103 зорилт дэвшүүлсэн бөгөөд эдгээр нь 2024 он хүртэл аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилтууд, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тусгаж хоорондын уялдааг хангасан байна. Жишээ нь: аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр 2017-2020 онд 8-аас доошгүй, 2021-2024 онд 12-оос доошгүй хувиар тус тус өсгөхөөр төлөвлөж энэ зорилтыг хангаж чадсанаар аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад зорилтыг хангах нөхцлийг бүрдүүлэхээр тооцсон байна.



Мөн түүнчлэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтын хоорондын уялдаа хангагдсан байна. Тухайлбал: аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд аймаг хөгжүүлэх хэтийн зорилтоос 112 зорилтыг тусгасан, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” хэтийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 140 зорилт, 498 арга хэмжээтэй тусган хэрэгжүүлж байна.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг боловсруулж төрийн албан хаагчид, 10-н төрийн бус байгууллага, 131-н иргэдийг оролцуулсан 10-д удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан 119 санал, зөвлөмжийг эрэмбэлэн нэгтгэж төсөлд тусгасан байна.

Ажлын хэсэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн төслийг боловсруулахдаа тодорхой хувилбаруудаар боловсруулаагүй байна.

А.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, хууль журамд заасан /бүтэц, агуулга, хүснэгт/ хүрээнд боловсруулж олон нийтээр хэлэлцсэн үү?

Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журмын хавсралт маягтаар гаргаж баталгаажуулаагүй байна.

Журмын 5 дугаар бүлгийн 24 дүгээр зүйлд “Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна” гэж заасан, мөн журмын 4 дүгээр хавсралтаар “Бодлогын баримт бичгийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ “ хийх маягыг баталсан.

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахдаа суурь судалгааг хэтийн зорилтын хувьд 2008-2016 оны үзүүлэлтээр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа 2013-2016 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг үндэслэн, улс, аймгийн статистик мэдээ, салбаруудын судалгаа болон сумдаас мэдээлэл авч дүн шинжилгээ хийжээ. Мөн Аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/519 тоот захирамжийн дагуу мэргэжлийн байгууллагын ажилтнуудаас бүрдсэн 4 ажлын хэсэг томилогдон сумдад ажиллан судалгаа мэдээллийг газар дээр нь үзэн, тулгаж баталгаажуулж ажилласан байна.

Хэдийгээр тодорхой судалгаа, үнэлгээний ажил хийгдсэн хэдий ч хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд журамд заасны дагуу хавсралт маягтаар нөлөөллийн урьдчилсан үнэлгээг гаргаагүй байна.

А.4 Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг бодитой тусгасан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг бодитой тусгажээ

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан. Хэтийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгүүдийн жил жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөвт тусган хэрэгжүүлж байна.

2017 онд бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг улс орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган 45.0 тэрбум төгрөгийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 2018 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай 152.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг улс, орон нутаг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

А.5 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг журамд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж, зөвшөөрөл авч эрх бүхий этгээдээр батлуулсан уу?

Аймгийн Засаг дарга аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг ИТХ-ын ажлын албанд өргөн барихдаа журмын 31 дүгээр зүйлийн 31.1-31.7-д заасан мэдээлэл, 1-6 дугаар хавсралт маягтуудаар гарган хүргүүлээгүй байна.

Журмын долдугаар бүлгийн 33-д “Аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг аймгийн Засаг дарга ИТХуралд хэлэлцүүлэхээр ажлын албанд хүргүүлэхдээ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ” гэж заасан

Аймгийн Засаг дарга аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг ИТХ-ын ажлын албанд өргөн барихдаа ИТХурлын дүрмийн 18-р зүйлийн 9-3 дах заалтын дагуу холбогдох баримт бичгийн хамт өргөн барьсан хэдий ч журмын 31 дүгээр зүйлийн 31.1-31.7-д заасан мэдээлэл, 1-6 дугаар хавсралт маягтуудаар гарган хүргүүлээгүй байна.

А.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү?

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг хууль, журамд заасны дагуу ажилласан боловч журмын хавсралт маягтуудаар хийгдсэн ажлаа албажуулж баталгаажуулаагүй байна

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь баримт бичгийн төсөл, бодлогын хувилбаруудын төслийг эцэслэн боловсруулж холбогдох хавсралтын хамт захиргааны байгууллага буюу аймгийн ЗДТГазарт хүлээлгэн өгөхөөр заасан. Төв аймгийн хувьд ажлын хэсэг нөхцөл байдлын шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, олон нийтээр хэлэлцүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн боловч журамд заасан үйл ажиллагаа зохион

байгуулах төлөвлөгөө гаргаагүй, хийсэн ажлаа журмын хавсралт маягтуудаар гаргаж баталгаажуулаагүй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх

Бүлэг 2 *Аймаг, орон нутагт хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах хугацаа болоогүй байна*

Б.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнасан уу?

Аймаг, орон нутагт хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах хугацаа болоогүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “энэ хуулийн 7-16 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлагдсан.

Аймаг, орон нутгийн түвшинд аймаг хөгжүүлэх хэтийн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл гэсэн бодлогын баримт бичгүүд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн хүрээнд боловсруулагдан батлагдаж хэрэгжиж байна.

Эдгээрээс аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын хувьд хуульд зааснаар хоёр жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэж тайланг ИТХурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ёстой. “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилт нь 2017 оны 2 дугаар сарын 20-нд батлагдсан бөгөөд батлагдсанаас хойш хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэх хугацаа болоогүй байна.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хувьд хуульд хоёр жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ИТХуралд танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр заасан. Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд нь 2016 оны сүүл, 2017 онд батлагдсан тул хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэх хугацаа болоогүй байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хувьд 2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХэлтэс нэгтгэн гаргаж, гүйцэтгэлийг 69.52 хувьтай гэж дүгнэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулан хэлэлцүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 сарын 10-ны өдрийн хуралдааны 18 тоот тэмдэглэл гарч тодорхой үүргүүд өгөгджээ. Аймгийн

эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжлүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан, хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д заасан хугацааг баримтлан аймгийн ИТХ-д өргөн барьснаар 2017 оны 09 сарын 29-ны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI хуралдааны 01 тоот тогтоолоор баталсан байна. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ” гэж заасан бөгөөд аймгийн 2017 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй байна.

Сумдын үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хувьд ЗДТГ-ын ХШҮДАХэлтэс хагас жилээр хэрэгжилтийн байдлыг нэгтгэн гаргасан.

Сумын нэр	Үндсэн чиглэлийн дундаж үнэлгээ		
	оноо	хувь	үнэлгээ
Алтанбулаг	27.00	90.00	А
Аргалант	27.00	90.00	А
Архуст	27.00	90.00	А
Батсүмбэр	18.00	60.00	С
Баян	30.00	100.00	А
Баяндэлгэр	25.00	83.33	В
Баянжаргалан	23.00	76.67	В
Баян-Өнжүүл	24.00	80.00	В
Баянхангай	27.00	90.00	А
Баянцагаан	24.00	80.00	В
Баянцогт	26.00	86.67	В
Баянчандмань	24.00	80.00	В
Борнуур	20.40	68.00	С
Бүрэн	24.00	80.00	В
Дэлгэрхаан	30.00	100.00	А
Жаргалант	24.00	80.00	В
Заамар	24.67	82.23	В
Лүн	28.89	96.30	А
Мөнгөнморьт	27.00	90.00	А
Өндөрширээт	21.00	70.00	В
Сэргэлэн	24.00	80.00	В
Сүмбэр	15.00	50.00	Д
Угтаалцайдам	25.00	83.33	В
Цээл	27.00	90.00	А
Эрдэнэ	25.00	83.33	В
Эрдэнэсант	25.50	85.00	В
Зуунмод	25.00	83.33	В
Дундаж	24.76	82.53	

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1-р хавсралтаар батлагдсан хугацаагаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг сумын ИТХуралд танилцуулан аймгийн Засаг даргад 2 дугаар сарын 01-ны дотор ирүүлэхээр заасан ба мөн тайлагнах хугацаа болоогүй байна.

Б.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулж байна уу?

Хууль болон журамд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах, холбогдох байгууллагад танилцуулах хугацаа болоогүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14, 15, 16 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1-р хавсралтаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацааг тогтоож өгсөн. Хууль болон журамд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах, холбогдох байгууллагад танилцуулах хугацаа болоогүй байна.

Б.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын “ 4 дүгээр зүйлийн 4.1-д “Бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна”, 4.4-д “Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй” гэж заасан

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтэс хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэж, ХШҮДАХэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Бүлэг 3

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байна

В.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байна уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байна

Хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна” гэж заасан.

Аймаг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл гэсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг tov.gov.mn, tov.khural.mn веб сайтуудад байршуулан олон нийтэд хүргэж байна. Мөн түүнчлэн өргөн нэвтрүүлгийн Өлзий телевиз, орон нутгийн Төв телевиз, TBS телевиз, өдөр тутмын Зууны мэдээ, Үндэсний шуудан зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдтэй хамтран ажиллаж Төв аймгийн эфирийн цаг болон буланд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг мэдээ, мэдээлэл, ярилцлага, нийтлэл хэлбэрээр сурталчилан ажилласан байна.

Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1000 ширхэг, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Ажилтай орлоготой иргэн” урианы жилийн төлөвлөгөөг 500 ширхэгийг товхимол болгон эмхэтгэн хэвлүүлж төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдэд хүргэх арга хэмжээ авч ажилласан байна.

В.2 Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ хууль, журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Орон нутгийн ИТХурал хууль, журамд заасан үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна.

Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын гуравдугаар бүлгийн 19 дүгээр зүйлд “Ажлын хэсэг төсөл, бодлогын хувилбаруудын төслийг эцэслэн боловсруулж, холбогдох хавсралтын хамт захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх” гэж заасан. Аймгийн хувьд нутгийн захирагааны байгууллага гэдэгт аймгийн ЗДТГ-ыг ойлгох бөгөөд ажлын хэсгээс бодлогын баримт бичгийн төслийг хавсралтын хамтаар хүлээж аваагүй байна.

Дээрх журмын тавдугаар бүлгийн 24 дүгээр зүйлд “Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна” гэж заасан. Аймгийн ЗДТГазар бус ажлын хэсэг нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийсэн боловч журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтаар хийж баримтжуулан баталгаажуулаагүй.

Мөн журмын долдугаар бүлгийн 33 дугаар зүйлд “Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ” гэж заасан боловч холбогдох мэдээллийг журмын хавсралт 6 маягтаар гаргаж хүргүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 17-д заасны дагуу төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасны дагуу нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийсэн боловч батлагдсан хавсралт маягтаар гарган баталгаажуулаагүй байна.
- Аймгийн Засаг дарга аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг ИТХ-ын ажлын албанд өргөн барихдаа Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 31 дүгээр зүйлийн 31.1-31.7-д заасан мэдээлэл, 1-6 дугаар хавсралт маягтуудаар гарган хүргүүлээгүй байна.
- Хууль болон Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах, холбогдох байгууллагад танилцуулах хугацаа болоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, ЗДТГазрын дарга Ч.Сарангэрэл, Төрийн захиргаа удидлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга Ч.Жавзанпагма нарт зөвлөх нь:

1. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн нэг болох жил жилийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулахдаа 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг баримтлан ажиллах

2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг холбогдох байгууллагуудад танилцуулан хүргүүлэхэд анхаарч ажиллах.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТОР

Ч.ЗАГДСҮРЭН

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

41100 Зууламдал, Төв аймаг
Утас: 70273025, Факс: 70272237

2017.12.20 № 01/2018
талай -ны № -т

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын дүгнэлтийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна.

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг хууль, журамд заасны дагуу ажилласан боловч журмын хавсралт маягтуудаар хийгдсэн ажлаа албажуулж баталгаажуулаагүй байна... гэсэн дүгнэлтийн хүрээнд:

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд 2016 оны 10-р сараас 2017 оны 02-р сарын 20-ны хооронд аймгийн ИТХ-аар батлагдсан. Иймд бодлогын баримт бичгүүдийн боловсруулалтай холбоотой материалуудыг батлагдсан маягтын дагуу Архивын тухай хуулийн 22-р зүйлийн 1.3 дахь заалт, архивын ерөнхий газрын даргын баталсан, “Байгууллагын архивын ажлын заавар”-ын 3.5.11-т зааснаар архивын нэгж үүсгэн 2018 оны 1-р улиралд багтаан, тушаахаар хүлээгдэж байна. /Бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад гарсан зорилго, зорилтын хувилбарууд, хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмж, нөлөөллийн үнэлгээний мэдээ, судалгаа, дүгнэлт зэргээр цахим архивын нэгж үүсгэсэн файл болон цаасан сууриар аудитын газарт хүргүүлэн танилцуулсан болно./

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг журмын 17-д заасны дагуу төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 8 дугаар сарын 12-ны А/475 тоот захирамжаар “Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл 2017-2024”, “Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл боловсруулах нэгдсэн ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөг боловсруулан, батлуулж ажилласан.

Төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: -2 хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Д.МӨНХБААТАР



01 1482

My doc: A4 Toot-2017 /bat/ch,4

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Холбогдох байгууллага буюу аймгийн Засаг даргын орлогч Д.Мөнхбаатар /ажлын хэсгийн ахлагч/ нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах хоёр тайлбарыг ирүүлсэн байна.

1.Бодлогын баримт бичгүүдийн боловсруулалттай холбоотой материалуудыг батлагдсан маягтын дагуу архивын тухай хууль тогтоомжийн дагуу архивын нэгж үүсгэн 2018 оны 1-р улиралд багтаан тушаахаар хүлээгдэж байна. Бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад гарсан зорилго, зорилтын хувилбарууд, хэлэлцүүлэгээс гарсан санал зөвлөмж, нөлөөллийн үнэлгээний мэдээ, судалгаа, дүгнэлт зэргээр цахим архивын нэгж үүсгэн файл болон цаасан сууриар аудитын газарт хүргүүлэн танилцуулсан болно гэсэн тайлбар ирүүлжээ.

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудаас цаасаар болон цахимаар баримт материал, файл гарган ирүүлсэн бөгөөд үүнд Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын хавсралтаар батлагдсан зургаан маягтаар хийгдсэн ажлуудаа гаргаагүй, холбогдох мэргэжилтнүүдээс тодруулж асуухад маягтуудыг хөтлөөгүй гэсэн тайлбар өгч байсан тул энэ саналын дагуу тайланд өөрчлөлт оруулах боломжгүй байна.

2.Бодлогын баримт бичиг баримтын төсөл боловсруулах ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөг боловсруулан, батлуулж ажилласан гээд хавсралтаар 2 хуудас төлөвлөгөө ирүүлсэн байна.

Аудитын явцад төлөвлөгөө байгаа эсэх байгаа бол гаргаж ирүүлэхийг холбогдох мэргэжилтнүүдэд удаа дараа тавьж байсан боловч албан ёсоор батлагдсан төлөвлөгөө төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй болно. Аудитын үе шатны ажлын үед батлагдсан төлөвлөгөө гаргаж ирүүлээгүй, тайлангийн төсөлтэй танилцсан өдрөө төлөвлөгөө гэж 2 хуудас ирүүлсэн тул энэ саналыг хүлээж авах боломжгүй.

Хавсралт 1

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүд

№	Дэд хөтөлбөр	Батлагдсан шийдвэр
1	“Эрүүл хүнс-эрүүл монгол хүн” дэд хөтөлбөр	Батлагдаагүй
2	“Аймгийн мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлого”	Батлагдаагүй
3	“Аймгийн газар тариалангийн талаар баримтлах бодлого”	Аймгийн ИТХТ-ийн 2017.04.26-ны “Бодлого батлах тухай” тогтоол Дугаар: 54
4	“Мах, сүүний аян” дэд хөтөлбөр	Батлагдаагүй
5	“Үр” дэд хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017.08.03-ны “Дэд хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/461 тоот захирамж
6	“Аймгийн тэжээл бэлтгэл, үйлдвэрлэл”-ийн дэд хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017.08.03-ны “Дэд хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/461 тоот захирамж
7	“Уринш, бордоо, ургамал хамгаалал” дэд хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017.08.03-ны “Дэд хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/461 тоот захирамж
8	“Техник, технологи, боловсон хүчний хангалт” дэд хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017.08.03-ны “Дэд хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/461 тоот захирамж
9	“Хүнсний ногоо” дэд хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017.08.03-ны “Дэд хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/461 тоот захирамж
10	“Аймгийн инновацийн дунд хугацааны хөтөлбөр”	Батлагдаагүй
11	“Аймгийн үйлдвэржилтийн бодлого”	Батлагдаагүй
12	“Ухаалаг-Төв” хөтөлбөр	Батлагдаагүй
13	“Нийтийн аж ахуйн талаар аймгаас баримтлах бодлого”	Аймгийн Засаг даргын 2017.06.29-ны “Аймгийн нийтийн аж ахуйг хөгжүүлэх бодлого батлах тухай” Дугаар: 71 тоот захирамж
14	“Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” хөтөлбөр	Аймгийн ИТХТ-ийн 2017.07.20-ны “Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөө” батлах тухай тогтоол Дугаар: 79
15	“Цөлжилтийг бууруулах аймгийн бодлого”	Аймгийн ИТХТ-ийн 2017.08.31-ний “Цөлжилттэй тэмцэх, үндэсний хөтөлбөр”-ийн төлөвлөгөө батлах тухай тогтоол Дугаар: 102
16	“Хөгжсөн багшаас чадварлаг сурагч” дэд хөтөлбөр	Батлагдаагүй
17	“Хүүхдийг сургаж, төлөвшүүлэх” дэд хөтөлбөр	Батлагдаагүй
18	“Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөр	Батлагдаагүй
19	“Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөр	Аймгийн ИТХТ-ийн 2016.09.15-ны “Элэг бүтэн-Төв аймагчууд” хөтөлбөр батлах тухай тогтоол Дугаар: 22
20	“Залуучуудын талаар баримтлах бодлого”	Аймгийн ИТХТ-ийн 2017.04.06-ны “Бодлого батлах тухай” тогтоол, дугаар: 38
21	“Хөдөлмөр эрхлэлт” дэд хөтөлбөр	Аймгийн ИТХТ-ийн 2017.03.07-ны “Хөтөлбөр батлах тухай” тогтоол, Дугаар: 36

22	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах” дэд хөтөлбөр	Аймгийн ИТХТ-ийн 2017.04.06-ны “Хөтөлбөр батлах тухай” тогтоол, Дугаар: 39
23	“Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”	Аймгийн ИТХТ-ийн 2017.01.12-ны “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай тогтоол, Дугаар: 06
24	“Сувилагч” хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2017.08.11-ний “Хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/475 тоот захирамж
25	“Нийгмийн салбарын боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”	Батлагдаагүй
26	Төрийн албан хаагчдыг ажлын байранд дадлагажуулах сургалтын хөтөлбөр”	Аймгийн Засаг даргын 2017.06.27-ны “Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж, чадавхижуулах хөтөлбөр батлах тухай” Дугаар: А/369 тоот захирамж
27	“Гамшгийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах аймгийн хөтөлбөр”	Батлагдаагүй
	“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Төв аймгийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө”	Аймгийн ИТХТ-ийн 2017.04.26-ны “Бодлого батлах тухай” тогтоол, Дугаар: 51
	“Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө”	Аймгийн ИТХТ-ийн 2017.07.20-ны “Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” тогтоол, Дугаар:80

Хавсралт 2

Сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр,
үндсэн чиглэлийн товчоо

№	Сум	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр			Сумдын 2017 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл		
		зорилт	хэрэгжүүлэх арга хэмжээ	Батлагдсан шийдвэрийн хугацаа	зорилт	хэрэгжүүлэх арга хэмжээ	Батлагдсан шийдвэрийн хугацаа
1	Алтанбулаг	57	179	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 01 тоот тогтоол	83	216	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 02 тоот тогтоол
2	Аргалант	67	145	Сумын ИТХ-ын 2016.11.23-ны 01 тоот тогтоол	67	155	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 02 тоот тогтоол
3	Архуст	45	95	Сумын ИТХ-ын 2016.11.17-ны 01 тоот тогтоол	45	93	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 02 тоот тогтоол
4	Батсүмбэр	92	207	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 01 тоот тогтоол	76	174	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 02 тоот тогтоол
5	Баян	68	181	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 01 тоот тогтоол	57		Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 02 тоот тогтоол
6	Баяндэлгэр	76	162	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 02 тоот тогтоол	75	148	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 03 тоот тогтоол
7	Баянжаргалан	93	250	Сумын ИТХ-ын 2016.11.28-ны 08 тоот тогтоол	83	191	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 01 тоот тогтоол
8	Баян-Өнжүүл	72	172	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 01 тоот тогтоол	79	130	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 02 тоот тогтоол
9	Баянхангай	56	113	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 09 тоот тогтоол	68	93	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 03 тоот тогтоол
10	Баянцагаан	84	202	Сумын ИТХ-ын 2016.12.14-ны 01 тоот тогтоол			Сумын ИТХ-ын 2016.12.14-ны 02 тоот тогтоол
11	Баянцогт	88	212	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 01 тоот тогтоол	76	194	Сумын ИТХ-ын 2017.01.23-ны 01 тоот тогтоол
12	Баянчандмань	87	246	Сумын ИТХ-ын 2016.12.19-ны 02/03 тоот тогтоол	91	222	Сумын ИТХ-ын 2016.12.21-ны 02/04 тоот тогтоол
13	Борнуур	127	257	Сумын ИТХ-ын 2017.01.12-ны 01 тоот тогтоол	115	254	Сумын ИТХ-ын 2017.01.13-ны 02 тоот тогтоол

14	Бүрэн	73	158	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 01 тоот тогтоол	64	141	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 02 тоот тогтоол
15	Дэлгэрхаан	69	181	Сумын ИТХ-ын 2016.12.22-ны 01 тоот тогтоол	65	164	Сумын ИТХ-ын 2016.12.22-ны 02 тоот тогтоол
16	Жаргалант	77	196	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 01 тоот тогтоол	76	166	Сумын ИТХ-ын 2016.12.15-ны 02 тоот тогтоол
17	Заамар	75	198	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 05 тоот тогтоол	73	203	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 06 тоот тогтоол
18	Зуунмод	66	173	Сумын ИТХ-ын 2016.12.14-ний 01 тоот тогтоол	67	188	Сумын ИТХ-ын 2016.12.14-ний 03 тоот тогтоол
19	Лүн	89	206	Сумын ИТХ-ын 2016.12.12-ний 05 тоот тогтоол	76	186	Сумын ИТХ-ын 2016.12.12-ний 07 тоот тогтоол
20	Мөнгөнморьт	91	241	Сумын ИТХ-ын 2017.02.15-ны 01 тоот тогтоол	102	284	Сумын ИТХ-ын 2017.02.15-ны 02 тоот тогтоол
21	Өндөрширээт	60	145	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 03 тоот тогтоол	2	124	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 03 тоот тогтоол
22	Сүмбэр	6	196	Сумын ИТХ-ын 2016.12.21-ны 01 тоот тогтоол	8	208	Сумын ИТХ-ын 2016.12.21-ны 02 тоот тогтоол
23	Сэргэлэн	5	104	Сумын ИТХ-ын 2016.12.18-ний 04 тоот тогтоол	7	85	Сумын ИТХ-ын 2016.12.18-ний 05 тоот тогтоол
24	Угтаал	58	130	Сумын ИТХ-ын 2016.12.19-ний 01 тоот тогтоол	64	154	Сумын ИТХ-ын 2016.12.19-ний 02 тоот тогтоол
25	Цээл	68	146	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 01 тоот тогтоол	75	140	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 02 тоот тогтоол
26	Эрдэнэ	90	213	Сумын ИТХ-ын 2016.11.22-ны 01 тоот тогтоол	99	255	Сумын ИТХ-ын 2016.12.16-ны 01 тоот тогтоол
27	Эрдэнэсант	88	230	Сумын ИТХ-ын 2017.01.09-ны 01 тоот тогтоол	93	269	Сумын ИТХ-ын 2017.01.09-ны 02 тоот тогтоол